

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-32
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	
	1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	34-85
	2. “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенц” соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	85-90
	3. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	90-101
	4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 7 гишүүн 2019.12.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	101-108
	5. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	108-117
	6. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	117-145

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 38 гишүүн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 45 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батзандан, О.Батнасан, Ц.Гарамжав, Б.Дэлгэрсайхан, С.Жавхлан, Ц.Мөнх-Оргил, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, Д.Мурат, Н.Номтойбаяр, Д.Оюунхорол, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Я.Санжмятав, Б.Саранчимэг, Г.Солтан, Ч.Хүрэлбаатар,

Д.Цогтбаатар, Л.Элдэв-Очир, М.Энхболд, Ө.Энхтүвшин, С.Эрдэнэ,
Д.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, С.Батболд, Д.Ганболд,
О.Содбилэг, Ж.Энхбаяр;

Тасалсан: Б.Наранхүү, Д.Сумъяабазар, А.Сүхбат.

.....
Гурав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Э.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал, Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар, Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль, эрх зүйн газрын хэлтсийн дарга Р.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлагын газрын дарга П.Зоригтбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Болормаа, Б.Хатантуул, референт Б.Золбоо нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Нямбаатар, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 37 минутад хэлэлцэж дуусаав.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

.....

Гурав. "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл.
/Анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Сандагийн Бямбацогт даргын индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монголын ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, хөгжил дэвшлийн шинэ үе рүү шилжих эрх зүйн баталгаа болсон Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийхээр заасантай холбогдуулан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хороо боловсруулж Төрийн байгуулалтын байнгын хороо 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Тогтоолын төслөөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаа нь холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх ач холбогдлыг нь ард түмэнд сурталчлан таниулах зорилтыг иш үндэс болгон Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэдэд сурталчлах ажлыг улс орон даяар зохион байгуулахыг Засгийн газар, Улсын Их Хурлын Тамгын газарт тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус даалгаж хуваарийг хавсралтаар батлахаар боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед тогтоолын төсөл болон түүний хавсралт найруулгын шинжтэй зарим засвар оруулах саналыг Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар гаргасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэж дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Ш.Раднаасэд гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгээд бид нар дээр бол энэ Байнгын хорооны санал, дүгнэлт ирсэн. Тогтоолынх нь төсөл ирээгүй байх юм.

Тэгээд энэ дотор юу багтаж байгаа юм бол гэж. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ гэж байна. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдаж байх үеэр энэ дагаж

гарах хуульд нь өөрчлөлтийг оруулна гэж ярьж байсан энэ асуудлууд маань энд багтаж байгаа юу? Тухайлах юм бол засаг захиргааны нэгжтэй холбоотой, энэ Монголчуудын төрт ёсны энэ үзэл сэтгэлгээний нэг үндэс болсон тэр аравт, хорины зохион байгуулалтыг оруулах тухай асуудал яригдаж байсан. Энийг Д.Лүндээжанцан багш яг өөрийн биеэр амласан байгаа. Тэгэхээр энэ хаана явж байна. Орсон уу гэж.

Хоёрдугаарт нь, энэ орон нутгийн чанартай хот, тосгоны асуудал хаана байх вэ? Тухайлах юм бол манай Бор-Өндөр хотын статусын тухай асуудал гэх мэтчилэнгээр ийм зүйлүүд нь байх уу? Хөвсгөлийн Хатгал, Завханы Тосонцэнгэл, манай Хэнтий аймгийн энэ Монгол Улсын хамгийн анхны уул уурхайн хот болох Бэрх хотын асуудал гээд ингээд асуудлууд байж байгаа. Цаашлах юм бол энэ сум, сангийн аж ахуй байж байгаад татан буугдсан олон арван газрууд байж байгаа. Өнөөдөр багийн статустай. Сүхбаатар аймгаас одоо Түмэнцогт ч гэдэг юм уу, эсвэл манай Хэнтий аймгийн Өлзийт, Хурх, Хэрлэнбаян-Улаан, Тахилгат гээд ингээд тоолох юм бол зөндөө болно л доо.

Тэгэхээр энэ нэг асуудлуудыг нэгэнт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн томоохон өөрчлөлтийг хийсэн гэж ингэж үзэж байгаа учраас энэ орон нутгийн засаг захиргаатай холбоотой, орон нутгийн бүсийн шинж чанартай энэ хот, тосгоны эрх зүйн байдлын ийм асуудлуудыг нь хэрхэн шийдвэрлэгдэх вэ. Энийг цаг алдахгүй энэ өөрчлөлтөд оруулах байх гэж ингэж л ойлгогдоод байгаа. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Э.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалан, А.Даваажаргал Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Б.Бундхорол Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор, С.Энхбаатар Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор, Р.Энхтайван Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль эрх зүйн газрын хэлтсийн дарга, П.Зоригтбаатар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлагын газрын дарга, Н.Мягмар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга. Наашаа сууцгаа.

П.Зоригтбаатар дарга, Н.Мягмар дарга хоёр ийшээ суучих. Тэр Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль оруулж ирэх ёстой.

С.Бямбацогт дарга асуултад хариулна. С.Бямбацогт даргын микрофоныг өгье. Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлаас тогтоол гаргаж байгаа. Тогтоол маань бас хавсралттай. Хавсралт дээр маш тодорхой хуулиудад ямар өөрчлөлт орох талаар бас тодорхой тусгасан байгаа. Энэ дээр тухайлах юм бол нийтдээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан дагаж нийт 45 хуульд нэмэлт, өөрчлөлт орно. 45 хуулиас 2 нь анхдагч хууль.

12 хууль нь шинэчилсэн найруулга. 23 хууль нь нэмэлт, өөрчлөлт байж байгаа.

Үүн дотроо таны асууж байгаа тэр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүнтэй холбоотой асуудлуудыг шийдэх маш тодорхой заалтууд орсон байгаа. Тогтоолын хавсралтын 4 дүгээр бүлэг дээр хот, тосгоны эрх зүйн байдлыг тодорхой болгох асуудлаар үзэл баримтлалын чиглэлээр дараах чиглэл баримтална. Үүнд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, түүнчлэн тосгоны эрх зүйн үндэс, тэдгээрийн өөрийн удирдлагын болон засаг захиргааны зохион байгуулалтын зарчмыг хуулиар тогтооно. Хот, тосгоны өөрийн удирдлагыг оршин суугчид нь сонгож хот, тосгоны удирдлага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын болон төсөв, санхүүгийн зарим эрх мэдлийг шилжүүлэх, удирдлагын давхардал, хийдлийг арилгах, хот нийтийн үйлчилгээ, оршин суугчдад төрийн үйлчилгээ иргэдэд ойртох, эдийн засгийн хувьд хот, тосгон харьцангуй бие дааж хөгжих боломжийг бүрдүүлэх гэсэн үзэл баримтлалын хүрээнд хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлах ёстой шүү гэсэн тогтоолыг Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл болгож өгч байгаа.

Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх журамтай холбоотойгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг тухайн нутгийн иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэх зарчмыг хэвээр хадгалаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт чиглэл болгож оруулж ирж байгаа.

Мөн нутгийн өөрөө удирдах ёсны эрх зүйн үндсийг тогтоохтой холбоотойгоор үзэл баримтлалын чиглэлээр дараах чиглэл баримтална гэж байгаа. Энэ одоо аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны чөлөөт цагт тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж ирсэн тогтолцоог халъя.

Иргэдийн хурал нь шаардлагатай тохиолдолд хуралдаж асуудлаа шийддэг байя. Иргэдийн хурлаар бас хуулиар тогтоосон хүрээ хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоож болохоор одоо ийм заалтууд орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол бид нар Үндсэн хуулийг хэлэлцэж баталж байх үед ярьж байсан төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх, мөн улсын болон орон нутгийн чанартай хот, тосгоныг байгуулах ийм бололцоо боломж Үндсэн хуулиар нээгдсэн. Үүнтэй холбоотой зохицуулалтуудыг одоо маш тодорхой оруулж ирнэ шүү гэдэг ийм Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа. Энэ агуулгын хүрээнд зохицуулалтууд хийгдэж өргөн баригдаж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ 2020 ондоо багтаагаад 2020 оны хавар одоо бас энэ хаврын чуулганаар багтаагаад зарим хуулиудыг зайлшгүй батлах ёстой гэж үзэж байгаа. Энэ хүрээнд үндсэндээ хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль гэсэн хуулиудыг бид энэ хаврын чуулганаар баталчихъя гэсэн тийм бодлого, зорилго тавьж ажиллаж байгаа. Бас Засгийн газар энэ тал дээр бас анхаарч ойрын үед Улсын Их Хуралд боловсруулж өргөн мэдүүлэх байх гэж бодож байна.

Ингэх юм бол одоо таны хэлж байгаа тэр зарим 21 аймгийн төв хот болох. Улаанбаатар хотын эрх мэдэл бие дааж үйл ажиллагаа явуулах бололцоо боломж нэмэгдэх, зарим тосгод одоо бас хотын статусаа, тосгоны статустай болох асуудлууд бол бүрэн шийдэгдэх бололцоотой. Олон жил яригдсан. 1992 оноос хойш шийдэж чадаагүй асуудал үндсэндээ энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдсэн. Үүнийгээ одоо өшөө Үндсэн хуулийн салбарлан гарах хуулиудтай маш тодорхой тусгаж оруулж ирэхээр болж байгаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр байгалийн баялгийн зохицуулалтын талаарх энэ Ашигт малтмалын хууль гээд хэд хэдэн хуулиудад өөрчлөлт оруулахаар энэ тогтоолын төсөлд хавсралт сая ирлээ л дээ. Тэгээд энийг харах юм бол оруулсан байна л даа. Тэгээд тухайлах юм бол стратегийн ач холбогдолтой орд газрын талаарх зохицуулалтыг хэрхэн боловсронгуй болгох юм. Энэ байгалийн баялаг, ялангуяа энэ хүний аюулгүй, эрүүл орчинд амьдрах энэ Үндсэн хуулиар баталгаажуулсан эрхийг зөрчсөнтэй холбоотойгоор асуудлуудыг шийдэх ийм шаардлагатай байна л даа. Тухайлах юм бол Хэнтий аймгийн түүхэн аялал жуулчлалын бүс болгоод Засгийн газар шийдсэн байдаг. Тэгтэл Ононгийн эхэн дээр алтны уурхай ухаад байдаг. Энэ нөхдүүд маань хууль зөрчөөд лицензийг авчихсан. Шургадагийн гол, Гутайн гол гэдгийг одоо бүр газрын зургаас хасаж байгаад одоо энэ лицензийг авсан шүү дээ. Одоо ингээд шүүхэд хандана, Үндсэн хуулийн цэцэд хандана гээд энэ улсууд маань яваад байдаг. Ийм мэт зүйлүүдийг одоо энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялагтай холбоотой. Урьд нь байгалийн баялаг бол төрийн өмч мөн гэсэн ганцхан зохицуулалт байсан бол одоо байгалийн баялаг төрийн өмч мөн. Байгалийн баялгийг Монгол төрийн бас урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо болон ирээдүй, хойч үедээ үр өгөөжтэй байх. Ард түмэнд дийлэнхэд хүртдэг байх ийм зарчмуудыг суулгаж өгсөн.

Үүнтэй холбоотойгоор бид Үндсэн хуулиас урган гарах органик хуулиудтай нийт 10 орчим хуульд яг одоо энэ Үндсэн хуульд заасан агуулгууд өшөө илүү баяжуулж, дэлгэрүүлж, өшөө илүү тодорхой болгож бас оруулж ирэхээр тусгасан байгаа. Тухайлах юм бол одоо Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, мөн Цөмийн энергийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль гээд анхдагч хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэдэг юм уу, байгалийн баялгийг байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар иргэн мэдэх эрхтэй гэж Үндсэн хуульд заалт орсон. Үүнтэй холбоотой бас Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг. Гэх мэтийн хуулиудад тодорхой өөрчлөлтүүд оруулахаар тусгасан байгаа. Нийтдээ 10 орчим хуульд өөрчлөлт орно.

Г.Занданшатар: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Н.Мягмар дарга, П.Зоригтбаатар дарга нар анхаараад энэ нэгдүгээр улиралдаа багтааж хаврын чуулганаас өмнө Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийг оруулж ирж Хот, тосгоны эрх зүйн байдал. Тэр 40 гаруй тосгод багийн статустай тосгон болох шаардлагатай газрууд байгаа. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд. Тэрийг анхаарах юм байна шүү. Энэ хуульд заасан. Хуваарь баталсан байгаа.

Хишгээгийн Нямбаатар гишүүн асуулт асууна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би уг нь Хэрэг эрхлэх газраас асууя л гэж бодож байна.

Энэ ямар тийм баг авч ажиллуулж байна. Энэ нэлээн тийм том өөрчлөлтүүд орж ирнэ. Эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэй тодорхой хөрөнгө хүч, санхүү гаргасан хууль хоорондын уялдааг хангасан ийм их том ажлын хэсгүүд гарч ажиллах учиртай.

Тэгэхээр энийг нэгдүгээрт хэлмээр байна. Сая С.Бямбацогт даргын хэлж байгаагаар 2020 оны хаврын чуулганаар Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Шүүхийн тухай хууль гэх мэт хуулиудыг тэргүүн ээлжинд нь авч хэлэлцье гэж байх шиг байна.

Тэгэхээр өнөөдрийн бид нарын батлах гэж байгаа тогтоолоор бол дийлэнх, бараг 90 хувь нь 2020 ондоо батлуулахаар ингээд хуваарь орчихсон байгаа.

Хоёр гэвэл Үндсэн хууль дагаж мөрдөх журмын тухай хууль гэж бид нар хуулиар шилжилт хийхдээ бас тодорхой цаг хугацаанууд тавьсан ийм зохицуулалттай байгаа. Тэгээд энэ олон хуулиуд дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зөвхөн өөрийнхөө яамдын болон өөрийнхөө дотоод нөөцөд тулгуурлаж энэ ажлын хэсэг дээр ажиллах гэж байна уу, эсхүл гаднаас эрдэмтэн судлаачид, практикийн ажилтнуудыг татан оролцуулж ийм том баг гаргаж ажиллах гэж байна уу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрт гэвэл бид нар ерөөсөө батлаад сар гаруй, хоёрхон хугацаанд энэ Үндсэн хуулийн 57.3-т орсон концепцоосоо жаахан зөрж эхлээд байгаа шүү дээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргийг улсын болон орон нутгийн шинж чанартай хотуудыг байгуулаад тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим чиг үүргүүдийг шилжүүлье. Энэ нь шат дараатай хийгдье гээд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан протокол дээр байгаа.

Энэ бол зөвхөн саяны нэр дурдсан цөөхөн хэдэн тэр суурин газруудаар тодорхойлогдохгүй. Цаашдаа Монгол Улсын энэ засаг захиргааны бүх нэгжүүдэд байгаа хүн ам төвлөрөн суурьшсан энэ газруудыг бүхэлдээ улсын болон орон нутгийн шинж чанартай хотууд болгох шат дараатай системтэй ажлуудыг хийе. Тэдгээр нь хот суурингийн шинжтэйгээр үйл ажиллагаагаа явуулъя. Ариутгах татуурга, цэвэр, бохир ус, ундны усны хангамжтай больё.

Тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шилжүүлэх болох чиг үүргүүдийг өгье. Шилжүүлж болохгүй чиг үүргүүдийг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үндсэн тэр нэгжүүдэд нь хадгалж үлдээе гэдэг ийм юм ярьсан. Одоо сүүлдээ ерөөсөө сонгууль дөхөхөөр нөгөө нэр дэвшигчид өөрөө өөрсдийнхөө тэр сонгогдсон газрынхаа тодорхой нэршлүүдийг хэлээд ийм маягаар энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг ийм сар гаруйн дараа энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн үндсэн тэр агуулга юуг ганцхан зүйлийн агуулгыг гэхэд ингэж гуйвуулж бид нар хэдүүлээ цаашдаа ярьж болохгүй байх.

Цаашдаа бүх сумын төвүүд бол энэ суурин газар болно. Сум гэдэг нь том засаг захиргааны нэгж нь. Сумын төв нь магадгүй тосгон гэнэ үү, хот гэнэ үү, юу гэж нэрлэх нь одоо чухал биш. Цаашдаа энэ суурин соёл иргэншлийн чиг хандлагаар бид нар хөгжье л гэж байгаа бол бүхэлдээ энийг системтэй, бүсчилж ингэж хийж тэгээд энэ орон нутгийн төсвийнхөө бүтцэд аажимдаа шилжилтийг хийх замаар хүн амд нь таарсан хуваарилалтыг хийдэг. Төвлөрч суурьшсаныхаа хэрээр өөрсдөө үйлчилгээний болон бусад татваруудаа өөрсдөө тогтоодог энэ чиг хандлага руу явъя гэж л бид нар энэ 57.3 дээр нэмэлт, өөрчлөлт оруулсан шүү дээ.

Тэгэхээр энийг бас энэ ажлын хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар цаашид энийгээ анхаарч ажиллаарай. Тэрнээс биш энэ зөвхөн саяны нэр дурдсан хорин хэд гэнэ үү, гучин хэдэн тийм юугаар суурин газраар энэ тодорхойлогдохгүй. Мэдээж хэрэг хамгийн түрүүнд Эрдэнэт, Дарханы асуудал яригдана. Дараа нь тэр одоо юу гэдэг юм бусад суурин газруудын асуудлууд яригдаж бүхэлдээ шилжилтүүд тэдэн жилийн дараа хийгдэж дуусах учиртай л ийм шилжилт хөдөлгөөний асуудал. Энэ дээр бүр тэгсэн шүү дээ. Хууль гаргана гэж нэрлэсэн шүү дээ. Тухай бүрт нь хууль гаргаж чиг үүргийг нь шилжүүлж байхаар ингэж хуульчилсан.

Тэгэхээр би тэр эхнийхээ асуултад хариулт авъя. Ямар.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм? С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Х.Нямбаатар гишүүний хэлж байгаа зөв л дөө. Бид нар 1992 оны Үндсэн хуулиараа үндсэндээ Улаанбаатар хотоос бусад хотуудыг аймгийн төвүүд, Дархан, Эрдэнэт хотыг сум болгочихсон. Үүнтэй холбоотойгоор тодорхой зохицуулалтуудыг тухайн үед Үндсэн хуулийг баталж байх үедээ одоохондоо ингээд сум гээд явж байг. Ганцхан Улаанбаатар хоттой байцгаая. Яваандаа энийг бас Нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, бусад хуулиудаараа зохицуулчихна гэж явсан боловч сүүлийн хорин хэдэн жил, гучаад жил засаж чадаагүй.

Ингэхдээ бас Улаанбаатар хотын эрх мэдлийг ч гэсэн тодорхой хэмжээгээр хязгаарласан байсан. Тэгвэл энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярихдаа зөвхөн энэ удаа энэ 2019 онд ярьсан биш энэ сүүлийн арваад жил ярихдаа энэ Улаанбаатар хотоос гадна Дархан, Эрдэнэт хотыг, аймгийн төвүүдийг, тэр зарим шаардлагатай тосгонуудыг эрх зүйн байдлыг нь яаж дээрдүүлэх вэ, эрх мэдлийг нь яаж нэмэгдүүлэх вэ, яаж орон

нутаг, хотууд бие дааж хөгжих бололцоо боломжийг бий болгох вэ гэдэг чиглэлээр арваад жил ярьж ирсэн. Сүүлийн жил гаруйн хугацаанд ч гэсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах үедээ энэ чиглэлд анхаарсан. Энэ тал дээр олон гишүүд нэлээд маргаан дагуулж ярилцаж байсан.

Энэ хүрээндээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөхөд тодорхой, үндсэндээ тэр 57.2, 57.3, 59 дүгээр зүйлийн 2 гэсэн зохицуулалтуудыг бид нар оруулж ирсэн. Энийг илүү өргөн агуулгаар нь ойлгохоор. Ингэж өгснөөрөө бид нар үндсэндээ энэ Улаанбаатар болон 21 аймгийн төв, тэгээд орон нутагт бас эрх мэдлийг шилжүүлэх, төвлөрлийг сааруулах, зөвхөн Улсын Их Хурлын баталсан төсвийг хэрэгжүүлдэг байгууллага биш өөрсдөө бас бие дааж татвар хураамжаа тогтоох, өөрсдөө бас өмчийн удирдлагыг зохицуулах, өөрсдөө баталсан хуулийн хүрээнд журам зохицуулалтууд хийх энэ бололцоо боломжийг нь нээж өгч байгаа. Үндсэн хуулиар нээж өгнө гэж протоколд бид үндсэндээ тэгж ярилцаж оруулж ирсэн.

Үүнтэй холбоотойгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын тухай гэсэн бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт зайлшгүй орох шаардлага байгаа. Зарим хуулиуд нь шинэчлэн найруулагдана.

Энэ хүрээндээ үндсэндээ энэ орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх, төвлөрлийг сааруулах, орон нутагтаа бие даан хөгжих бас бололцоо боломжийг олгох чиглэлд оруулж хуулиуд дээр Засгийн газар маань илүү анхаарч энэ чиглэлдээ. Тэр Үндсэн хуулийг хэлэлцэж байх үед ярьж байсан протоколууд, мөн одоо бас урьд өмнө нь бас тулгамдаж байсан асуудлууд. Эдгээрийг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг дээр орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагуудын санал бодлыг бас нэлээн сайн сонсож энэ хүрээндээ Засгийн газар маань оруулж ирэх хуулиа нэлээн анхаарч оруулж өгөх ёстой. Энэ дээр одоо бас нэлээд их цаг хугацаа, хүн хүч шаардана. Тийм болохоор өшөө илүү өргөн бүрэлдэхүүнтэй суух ёстой.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль Улсын Их Хуралд өргөн баригдсан байж байгаа. Ж.Ганбаатар гишүүн ахалж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийг одоо Улсын Их Хуралд өргөн барьсан байсан. Д.Тогтохсүрэн гишүүн ахалж байгаа бас. Эдгээр одоо өшөө сайжруулах. Урьд нь бол юу гэдэг юм шинэ хууль хийхгүй бид нар. Урьд нь байсан хуулиа сайжруулна. Тийм болохоор тодорхой хэмжээнд бас хэлэлцээд явахад нэг их айхтар бэрхшээл гарахгүй болов уу гэж бодож байгаа. Үндсэндээ бид асуудлаа тодорхойлсон. Бэрхшээлтэй тулгамдаж байгаа зүйлүүдээ бас ойлгомжтой болгосон. Хэрхэн яаж шийдүүлэх арга замаа тодорхойлсон байгаа. Ганцхан хууль эрх зүйн орчноо бүрдүүлэх жаахан дутуу байгаад байгаа.

Тийм болохоор Засгийн газар маань энэ тал дээр одоо бас Их Хуралд өргөн баригдсан хуулиуд дээр болон ажлын хэсгийнхэнтэй, дээрээс нь орон нутгийн удирдлагуудтайгаа бас нэлээн сайн хамтарч ажиллаж оруулж ирэх

байх. Ингээд ороод ирэх юм бол батлахад нэг их айхтар цаг хугацаа шаардахгүй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууна.

Ш.Раднаасэд: Энэ дотор энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгаагүй юмыг хөндөөд оруулаад ирэх юм.

Нөгөө стратегийн орд бүхий ордын ашигт малтмалын нөөц бүхий ордын дийлэнх хувь нь үр ашиг нь ард түмэнд хүрсэн ийм байх тухай заалт орсон. Тэгтэл аваачаад бүгдийг нь аваачаад ард түмэнд өгнө гээд энэ түгээмэл тархацтай ашигт малтмалын ой, ус, рашаан ургамлын ашигласны орлогын орон нутгийн хөгжилд зориулна гээд ингээд аваачаад хийчихсэн. Одоо наадах чинь юу болох юм гэхээр аймаг, нийслэлийн Засаг дарга нар чинь хаа хамаагүй газар аваачаад түгээмэл тархацтай гээд жаал газар ашигт малтмалын лицензүүд өгөөд эхэлнэ. Зөвшөөрөл өгөөд эхэлнэ. Энэ одоо гараад байгаа яаж таслан зогсоох вэ гээд шүдний өвчин болсон юм байгаа байхгүй юу. Нөгөө стратегийн ордоо тойрч, том ордуудаа тойрч юмаа явна гэсэн чинь ингээд аваачаад бүх Монголынхоо бүх газар нутгийг ухуулах юмыг аваачаад энэ дотор хийчих юм.

Одоо манай аймагт гэхэд аймгийн төвөөс 400, 500 километр газар түгээмэл тархацтай ашигт малтмалын орд гээд өгчихсөн байгаа байхгүй юу. Тэндээс хайрга, чулуу олборлоно, элс олборлоно гэж юу байх вэ дээ. Өөр зорилгоор л ухах гэж байгаа байхгүй юу. Тэгээд одоо энийг нь аваачаад орон нутгийн хөгжилд зориулна гээд хийчхээр бүх их хөшүүрэг болгоод өгчхөж байгаа байхгүй юу. Ингээд энэ хуулийн, нөгөө бид нарын анх бодож ярьж хийж байсан юм шиг ингээд нугалаа болоод замхарсан байна. Энийг нэгдүгээрт дахиж нэг анхаарч хараач ээ гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ Шүүхийн сахилгын хорооны хууль гэж тусдаа хууль гарах юм байна гэж би ойлголоо. Энэ Шүүхийн захиргааны тухай гээд хоёр хууль ингэж гарч ирнэ. Тэгээд сахилгын хороо тусдаа байх уу, үгүй юу гэдэг бол бас ярих л байх. Нэг хуулиар зохицуулах юм уу, хоёр хуулиар зохицуулах юм уу. Энэ нөгөө Үндэсний аюулгүй байдлын зөвлөл чинь одоо шүүгч нарыг татаж ирээд энийг түдгэлзүүлье, энийг больё гэдэг юмаа одоо энэ зохицуулалт дотроо хийж өгөх үү.

Шүүхийн ерөнхий зөвлөл 5-хан хүнтэй. 5 хүн нь Ерөнхийлөгчөөс томилогддог. Тэр 5 хүний гараар ороод л шүүгч болчихдог энэ юмыг халъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийг 10 хүний бүрэлдэхүүнтэй болгоё гээд ингээд нэлээн бүрэлдэхүүнийг нь өндөрсгөөд, тавигдах шалгуур шаардлагуудыг нь тавиад ингээд явсан. Энэ хүрээндээ энэ зохицуулалт чинь энэ Шүүхийн тухай хууль дээр яаж тусаж байгаа юу гэдгийг.

Гуравдугаарт, энэ тойргийн шүүх байгуулж болно л гэж бид хийсэн. Бид энэ ирээдүйг харж 10, 20 жилийн дараа юмыг яаж мэдэх вэ гэж л бодож хийсэн. Гэтэл энэ дээр одоо нэг Тойргийн шүүх байгуулах хууль ингээд л. Энэ чинь бас нэг 2014, 2015 оны үед нэг хэрэгжээд бас ард түмний эсэргүүцэлтэй тулаад больсон зүйл шүү дээ. Тэр давж заалдах шүүхийг зэргэлдээ аймгууд

дээр аваачиж өргөдөл чирэгдэл өгдөг ийм зүйл байсан юм. Энэ юмаа дахиад давтах гээд байгаа юм уу. Энийг тодруулмаар байгаа юм.

Гуравт нь одоо энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Ш.Раднаасэд гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ш.Раднаасэд: Энэ орон нутгийн зэрэглэлтэй тосгоны асуудлыг яриад байгаа юм. Энэ Б.Бат-Эрдэнэ гишүүн. Ялангуяа тэнд мянга гаруй хүн амьдардаг, ажилладаг. Манайд гэхэд 2 тосгон байдаг. Баянтоорой, Гуулин гээд тариалангийн аж ахуй байсан.

Энэ хуучин Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн бараг байнга л явдаг нэг хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгох, төсөв, өмч хөрөнгийн удирдлагын зохицуулалтыг нарийвчлан тусгах гээд нэг ийм байдаг л нэг ийм формат өгүүлбэрүүд бичээд байх юм. Яг орон нутгийн зэрэглэлтэй тосгоноо яаж ангилах юм, яаж гаргах юм? Улсын чанартай тосгоноо яаж гаргах юм гэдгээ энэ хуулийн төслөөр зохицуулах харилцааныхаа энэ товч утга дотор хийхгүй бол энэ хуулийн төслийг чинь бичиж байгаа хүмүүс энэ хүрээнд нь хийгээд бас л нэг бөөрөнхийлсөн байх ч юм шиг, байхгүй ч юм шиг. Тосгон нь яаж ажиллах нь ойлгомжгүй нэг ийм зүйл хийгээд орхичихно. Тэрийг Их Хурал дээр яг энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах үед ярьж байсан тэр агуулгуудаар нь.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн асуултад хариулна.

С.Бямбацогт: Ш.Раднаасэд гишүүний хэлж байгаа зүйлүүдийг бид маш анхаарах ёстой. Үндсэн хуулийн үг үсэг, цэг таслал болгон цаанаа бас утга агуулгатай. Үг үсэг болгон цаашаагаа бас бие даасан хууль болох ийм боломжтой.

Бид нар энэ байгалийн баялагтай холбоотой заалтыг ярьж байх үедээ ч гэсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж оруулж ирсэн. Энэ одоо үр өгөөж гэдэг утгыг бид нар өргөн утгаар нь ойлгоно. Нийгэм, эдийн засгийн үр өгөөж. Тийм үү. Энд зөвхөн төлбөр, татвар, хураамжаас гадна ногдол ашиг орно. Нийгэм, эдийн засгийн үр өгөөж өргөн агуулгаар нь ойлгоно шүү. Дийлэнх гэдэг үгийг бид нар 50-иас дээш хувь нь. Дийлэнх гэдэг нь одоо юу гэдэг юм тоон утгаар илэрхийлдэг. 66.6-аас дээш гэдэг утгаар нь биш 50 дээр нэмэх нь 1-ээс дээш гэдэг утгаар нь ойлгоно шүү гэж протоколд тэмдэглэгдэж ингэж санал хурааж шийдэгдэж байсан юм. Энэ болгон бас цаашдаа хууль болохдоо нэг үг болгон маань ингэж хууль болох ёстой.

Яг үүнтэй адилхан Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлийн баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн гээд орчихсон. Тэгэхээр түгээмэл тархацтай ашигт малтмал гэдэг чинь өөрөө газрын хэвлийн баялаг, төрийн нийтийн өмч учраас үүнтэй

холбоотой бид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, түгээмэл тархацтай хуульд өөрчлөлт оруулах ёстой болж байгаа юм.

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж байгаа юм. Чиглүүлнэ гэж. Тийм болохоор газрын хэвлийн баялаг гэдэгт маань үндсэндээ зөвхөн стратегийн ордын биш нийт газрын хэвлийн баялаг. Энд чинь ашигт малтмал нь орно. Түгээмэл тархацтай ашигт малтмал нь ч орно. Тэр утгаараа бид нар түгээмэл тархацтай ашигт малтмал болон одоо ой, ус, рашаан, ургамал, амьтныг ашигласны орлогын тодорхой хэсгийг тухайн орон нутгийн хөгжилд зориулъя. Түгээмэл тархацтай ашигт малтмал болон ой, ус, рашаан, ургамал, амьтныг ашиглахдаа байгалийн тэнцлийг хадгалах зохицуулалтыг бий болгоё. Ийм зохицуулалтуудыг Байгальд түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд оруулъя гэдэг агуулгаар оруулж ирсэн юм. Гэхдээ та бас анхаараад хоёр дахь хэлэлцүүлгийн явцад зайлшгүй анхаарах зүйлс байх юм бол саналаа бас хэлээрэй. Бид энэ тал дээр бас анхаарч ажиллая гэдгээ хэлье.

Шүүхийн сахилгын хороотой холбоотой асуудал дээр бас. Одоо үндсэндээ бол шүүхийн сахилгын хороо байхгүй. Шүүгч нарт ёс зүйн хариуцлага, одоо янз янзын асуудал үүсэхэд хариуцлага тооцдог байгууллага байхгүй. Тийм болохоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гурав нийлж байгаад шийдвэр гаргаад түдгэлзүүлэх барих асуудлыг шийдээд явж байгаа шүү дээ. Тийм болохоор энэ анхдагч Шүүхийн сахилгын хорооны тухай хууль, одоо энэ хууль батлагдаад энэ явсан цагаас, хэрэгжээд эхэлсэн цагаас эхлээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүн шүүгч, прокурорыг ажлаас нь чөлөөлдөг, томилдог энэ асуудал дуусгавар болно. Ингэж явах ёстой.

Үүнтэй холбоотойгоор бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд орж байгаа гол асуудал бол шүүхийг хараат бус байлгах, хараат бус ажиллуулах бололцоо боломжийг энэ Үндсэн хуулиар нээж өгсөн. Үүнтэй холбоотой Шүүхийн захиргааны тухай хууль шинэчилсэн найруулга хийгдэнэ. Энэ хүрээндээ үндсэндээ энэ зохицуулалтуудыг бүрэн хэн нэгнээс хараат бусаар үйл ажиллагаа явуулах бололцоо боломжийг бид нар энэ Шүүхийн захиргааны тухай хууль болон Шүүхийн сахилгын хорооны тухай хуулиар шийдэж өгнө гэж одоо бас ийм агуулгаар үзэл баримтлалдаа тодорхой оруулж ирж байгаа.

Тэр шүүхийг тойргийн зарчмаар байгуулах талаар тодорхой зохицуулалт орж байгаа. Яах аргагүй бас өнөөдөр амьдрал дээр бас тулгамдаж байгаа асуудлууд байгаа. Зарим газраа маш их ачаалалтай ажилладаг. Зарим газраа ямар ч ачаалал байдаггүй. Хэрэг нэг мөр шийдэж чаддаггүй. Тэгвэл энийг бас зарим харьцангуй одоо юу гэдэг юм уян хатан, ачааллыг нь жигдлэх үүднээс тодорхой хэмжээгээр бас зохицуулж болох заалт нэгэнт Үндсэн хуульд оруулсан учраас Үндсэн хуулийн энэ нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор шүүхийг тойргийн зарчмаар байгуулахдаа иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг, иргэдийн эрхийн баталгааг бодитой хангах, шүүгчийн ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгчийг мэргэшүүлэх, шүүхийн

үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжтэй болгох гэсэн чиглэлийн хүрээнд одоо бас энийг оруулъя гэдэг агуулгаар тогтоолын төсөлд тусгасан байгаа.

Гэхдээ мэдээж тодорхой саналууд байх юм бол бас нэмээд тусгаад эцсийн хэлэлцүүлгийн явцад саналуудыг хүлээж авах бололцоотой байгаа гэдгийг нэмж хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ц.Цогзолмаа гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Үг үгүй юу? Үг байхгүй юм байна. Дэмжсэн, дэмжээгүй үг байхгүй юм байна.

Энэ саяны хэлсэн гишүүдийн гаргасан саналуудыг эцсийн хэлэлцүүлэгт анхаарч найруулга, энэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, үзэл санаатай нийцүүлж өөрчилж засах хэрэгтэй юмнуудыг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд орно. Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр саяны юмнуудыг анхаараарай. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга анхаараарай. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, тэр дүүргүүдийн асуудал энэ тэр.

Дараагийн асуудалд орно.

.....

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД